



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот


Гоёл чимэглэлийн мод, сөөг нийлүүлэх, тарих,
арчилах ажил болон зүлэгжүүлэлтийн ажилд
хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол дүүргийн 7,8,9 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх "Ард Аюушийн өргөн чөлөө", Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх "Эскадрилын хөшөө" орчимд гацуур мод тарих, арчлах, орон сууцны хороолол дотор байгуулах "Ойн төгөл"-д тарих гоёл чимэглэлийн мод сөөг нийлүүлэх, Налайх дүүргийн "Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн"-г зүлэгжүүлэх ажилд зарцуулах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гоёл чимэглэлийн мод, сөөг нийлүүлэх, тарих, арчлах, зүлэг тарих ажлыг сонгон шалгаруулалтанд тэнцсэн цэцэрлэгжилтийн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, ажлын явц, гүйцэтгэл, агротехнологийн горимын мөрдөлтөнд Төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавьж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /ГУуганбаяр/- т үүрэг болгосугай.

3. Гоёл чимэглэлийн мод, сөөг нийлүүлэх, тарих, арчлах, зүлэгжүүлэлтийн ажилд шаардагдах нийт 418.000.000 /Дөрвөн зуун арван найман сая/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/ -д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал.doc.docx

1110300525

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 04 сарын 07 өдрийн
 А/188 тушаалын хавсралт



ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН МОД СӨӨГ НИЙЛҮҮЛЭХ,
 ТАРИХ, АРЧЛАХ АЖИЛ БОЛОН
 ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

д.д	Зардлын нэр төрөл	Төсөв / сая төгрөг/
1.	Ард Аюушийн өргөн чөлөөнд гацуур тарих ажил. Үүнд:	
	а/. Ард Аюушийн өр.чөлөө-1-р хэсэгт гацуур тарих	80.0
	б/. Ард Аюушийн өр.чөлөө - 2-р хэсэг гацуур тарих	70.0
	в/. АрдАюушийн өр.чөлөө – 3-р хэсэг гацуур тарих	75.0
2.	“Ойн төгөл”-д тарих мод сөөг худалдан авах ажил. Үүнд:	
	а./ Сүхбаатар, Баянзүрх, Хан-уул дүүрэгт “Ойн төгөл”-д тарих хүрэн навчит монос худалдан авах	44.0
	б/. Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт “Ойн төгөл”-д тарих хүрэн навчит монос худалдан авах	40.0
	в/. Ойн төгөлд тарих шар навчит хайлаас худалдан авах	28.0
3.	“Эскадрилын хөшөө” орчимд 180ш гацуур тарих ажил	36.0
4.	“Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн”-д зүлэгжүүлэлт хийх	
	“А” талбайг зүлэгжүүлэх	10.0
	“Б” талбайг зүлэгжүүлэх	10.0
5.	Ард Аюушийн өргөн чөлөөний 1000 ш гацуур модыг арчлах	25.0
	ДҮН /сая. төгрөг/	418.0